



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 01 өдөр

Дугаар 5-01

Мөрөн

— Ажилд томилж, ажлаас чөлөөлөх тухай —

Монгол улсын "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 35 дугаар зүйлийн 35.1.4, "Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоол зэргийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хүүхэд асрах чөлөөтэй байсан Лхагвасүрэнгийн Хишигжаргалыг хүсэлтийн дагуу 2019 оны 01 дүгээр сарын 1-нээс "Шинэ-Идэр" цаг уурын өртөөний техникчээр эргүүлэн томилсугай.
2. "Шинэ-Идэр" цаг уурын өртөөний техникчээр хүүхэд асрах чөлөөтэй ажилтаныг ажилдаа эргэн орох хүртэл хугацаанд ажиллаж байсан Д.Чанцалдуламын хөдөлмөрийн гэрээг 2019 оны 01 дүгээр сарын 1-ны өдрөөр дуусгавар болгосугай.
3. Л.Хишигжаргалын үндсэн цалинг Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээний ТҮ-6-2 дахь шатлалын дагуу 540846 /таван зуун дөчин мянга найман зуун дөчин зургаа/ төгрөгөөр тогтоосугай.
4. Д.Чанцалдуламтай холбогдох тооцоог хийж дуусгахыг ня-бо Н.Эрдэнэцэцэгт үүрэг болгосугай.
5. Л.Хишигжаргалын ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргийн биелэлтэнд заавар зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллахыг "Шинэ-Идэр" цаг уурын өртөөний дарга Ц.Нандмаа, Цаг уур, орчны технологийн хэлтсийн дарга Б.Өнөрбат нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Г.АДЬЯАСҮРЭН